*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН САЛБАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ДОРЖДАГВА ОВОГТОЙ ГАНЗОРИГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД19)-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ №1.1: ***МУТЖҮЧ-2.4.1, ЗГҮАХХТ.1.1.2.7.*** Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээн авна. | Холбогдох чиглэлээр шинээр хийж эхэлсэн болон 2024 онд үр дүнг нь хүлээн авсан судалгааны тоо (гүйцэтгэлд эзлэх хувь) | (КОВИД-19)-тай холбоотой хийгдэх судалгааны төсөлт ажлын үр дүнг хүлээн авсан | Манай орны нөхцөлд тохирсон ДЭМБ-ын шаардлагыг хангасан оношлуур, эм, биобэлдмэл, бусад тоног төхөөрөмж, хэрэглүүр зохион бүтээж үйлдвэрлэн хангах судалгаа хийнэ. | Уламжлалт анагаах ухааны чиглэлийн эрдэмтэд КОВИД-19 халдварын үед уламжлалт анагаах ухааны эм заслын эмчилгээний үр дүнг тооцох судалгааг хийж, КОВИД-19 халдварыг эмчлэх уламжлалт анагаах ухааны “Чун-7” эмийг шинээр бүтээж, уламжлалт анагаах ухааны эмнэлзүйн зааврыг боловсруулсан. Мөн Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн эрдэмтэд SARS-CoV-2 эсрэгбие агуулсан эмчилгээний сийвэнг | 2023 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинээр боловсруулж гаргасан байна.<br>КОВИД-19 халдварыг оношлох зориулалтаар ШУА-ийн Биологийн хүрээлэн “Шинэ төрлийн SARS-CoV-2 вирусийн эсрэг бие илрүүлэх оношлуур №2021/001”, АШУҮИС-ын “SARS-CoV-2-ийг шүлснээс шууд илрүүлэх бодит хугацааны ПГУ-ын цомог оношлуурын бүрдлийг тус тус бүтээсэн байна.<br><br>Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар 2024 онд “Монгол Улсад КОВИД-19 халдварыг үүсгэж буй SARS-CoV-2 вирусийн геномын хувилбарын тандалт”, “(КОВИД-19) вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа”, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины дараах дархлаа тогтцын судалгаа”, “SARS-CoV-2 ба Хепатитын дельта вирусийн халдварыг илрүүлэх шинэ үеийн серологийн оношлууруудыг зохион бүтээх” гэсэн нэр сэдэвтэй 4 судалгааны төслийн хэрэгжилтийн үр дүн, тайланг | | |



49

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцэн хүлээн авч, судалгааг хаах зөвшөөрлийг олгож, “Ердийн товлолт болон коронавируст халдвар (КОВИД-19), хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтын хөтөлбөрт жендерийн дүн шинжилгээ хийх үнэлгээ” гэсэн сэдэвт 1 судалгааны төсөлд судалгаа эхлүүлэх зөвшөөрөл олгосон байна.<br><br>Эдгээрээс “КОВИД-19-ийн халдвар болон вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын үнэлгээ”, “Монгол улсад SARS-CoV-2-ийн голомтолсон халдварын геномын судалгаа”, “(КОВИД-19) вакцины дархлаа сэргээх нэмэлт тунгийн дараах дархлааны хариу урвал болон урвал хүндрэлийг судлах нь”, “(КОВИД-19) вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа”, “Монгол улсад (КОВИД-19) халдварыг үүсгэж буй SARS-CoV-2 вирусийн геномын хувилбарын тандалтын судалгаа” гэсэн 5 төслийн хэрэгжилтийн үр дүн, тайланг яамны ШУТЗ-ийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хурал (11 дүгээр сарын 12-ны өдөр)-аар хэлэлцүүлж, дэмжин хүлээн авсан байна. | | |
| ХОЁР: МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ<br>2.4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгааны ажлыг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэх | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1: ***Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоол:***<br><br>Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлд нийцүүлэн улсын захиалгат болон цөм технологи (Дэвшилтэт технологи нэвтрүүлэх)-ийн төслүүдийг шалгаруулах, үр дүнг хүлээн авах ажлыг зохион байгуулах. | Ирүүлсэн төслийн захиалгаас дэмжигдсэн төслийн тоо (ШУТЗ-ийн шийдвэр)<br><br>Хэрэгжүүлэн дуусч, үр дүнг хүлээлгэн өгсөн төслийн тоо (ШУТЗ-ийн шийдвэр)<br><br>Явцын хяналт хийсэн төслийн тоо | | 10%-иас багагүй<br><br>7-оос багагүй<br><br>5-аас багагүй | 2024 онд ШУТЗ-ийг нийт 4 удаа хуралдуулсан байна.<br><br>ШУТС-аас санхүүжих улсын захиалгат болон цөм технологийн төслийн захиалгын нийт **77** санал ирснээс ач холбогдлоор нь эрэмбэлж улсын захиалгат 11 төсөл, цөм технологийн 5 төслийн захиалгын санал (нийт **16** төсөл)-ыг яамны ШУТЗ-ийн хурал (01 дүгээр сарын 30-ны өдрийн 1 дүгээр хурал)-д танилцуулж, дэмжсэний дунд ШУТС-д хүргүүлсэн.<br>ЭМЯ-ны ШУТЗ-ийн шийдвэр 24/001, Эрүүл мэндийн сайдаас ШУТС-ийн захиралд хүргүүлсэн 1а/442 тоот албан бичиг<br><br>ЭМЯ-ны захиалгаар, ШУТС-ийн санхүүжилтээр 2013-2023 онд хэрэгжүүлж дууссан 4 төслийн үр дүн, тайланг ШУТЗ-ийн 2 дугаар хурал (07 дугаар сарын 09-ний өдөр)-аар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гарсан. | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ЭМЯ-ны ШУТЗ-ийн шийдвэр 24/002-005<br><br>Түүнчлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэлийн төслийг (07 дугаар сарын 09-ний өдрийн 2 дугаар хурал) хэлэлцүүлж, мөн ажлын хэсгээс сонгон шалгаруулсан дэвшилтэт технологийн төслүүдийг хэлэлцүүлж, 15 төсөл, арга хэмжээг дэмжсэн шийдвэр гаргасан (09 дүгээр сарын 19-ний өдрийн 3 дугаар хурал).<br>ЭМЯ-ны ШУТЗ-ийн шийдвэр 24/006-020<br><br>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед ЭМЯ-ны захиалгаар, улсын төсвийн санхүүжилтээр ХӨСҮТ, АШУҮИС-д хэрэгжүүлсэн коронавирусийн халдвартай холбоотой судалгааны 5 төслийн хэрэгжилтийн үр дүн, тайланг ШУТЗ-ийн 4 дүгээр хурал (11 дүгээр сарын 12-ны өдөр)-аар хэлэлцэж, үр дүнг хүлээн авсан.<br>ЭМЯ-ны ШУТЗ-ийн шийдвэр 24/021-025 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 онд ШУТЗ-ийн нийт 25 тогтоол (эдгээрээс **9** нь яамны захиалгаар улсын төсвөөс санхүүжсэн төслийн үр дүнг хүлээн авсан)-ыг боловсруулж, ШУТЗ-ийн даргаар батлуулжээ.<br><br>ШУТС-ийн захирлын баталсан 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн удирдамжийн дагуу 06 дугаар сарын 03-ны өдөр Анагаахын шинжлэх ухааны үндэсний сургууль дээр хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дууссан ШУТС-ийн санхүүжилттэй суурь судалгаа, улсын захиалгат болон цөм технологийн төслүүд зэрэг нийт **36** төслийн явцын хяналтыг хийж, хэрэгжилтийг эрчимжүүлэх зөвлөмжийг өгсөн.<br><br>2024 он гарснаас хойш улсын төсвийн (ШУТС) санхүүжилтээр хэрэгжиж дууссан нийт 33 төслийн үр дүнг яамны дэргэдэх АУЁЗХХ-ны хурлаар хэлэлцэж, судалгаа эхлүүлэх 9, судалгаа хаах дүгнэлт 22, сорьц лабораторид тээвэрлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2 зөвшөөрөл (тогтоол)-ийг боловсруулж, батлуулсан.<br><br>ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр нийт 15 төслийн үр дүнд дүгнэлт өгөх шинжээчдийн томилолтыг Эрүүл мэндийн сайдаар (02 дугаар сарын 14, 11 дүгээр сарын 10) батлуулж, томилогдсон шинжээч нарт материалыг хянан магадлагаа хийлгүүлэхээр хүргүүлсэн. | | |
| 3. | Арга хэмжээ 2.2: ***Засгийн газрын 2022 оны 183 дугаар тогтоол:*** Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж батлуулна. | Ажлын хэсгийн тушаал, удирдамж (тоогоор) | | 1 | Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэрэгцээ шаардлагын үнэлгээ, тандалтын судалгааг эхлүүлж эрүүл мэндийн эрдэм шинжилгээний байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан.<br><br>Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийг 2025-2029 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор тэргүүлэх чиглэлийн жагсаалтад санал авах болон тодотгол хийх маягтуудыг түүнийг бөглөх удирдамж зааврын хамт боловсруулсан. ЭМЯ-ны харьяа тусгай мэргэжлийн төвүүд, | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 80 |



05

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | анагаахын чиглэлээр боловсрол олгодог их дээд сургуулиуд, эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг салбарын бус хүрээлэнгүүдийн дарга захирал нарт Эрүүл мэндийн сайдын 2024 оны 1а/4516 тоот албан бичгээр тэргүүлэх чиглэлийн санал ирүүлэх хүсэлтийг хүргүүлж хариуг авсан.<br><br>Тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлын хэсэг болон ажлын хэсэгт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх шинжээчдийг багийн бүрэлдэхүүнийг батлах Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг яамны газар, хэлтсийн дарга нараар хянуулж байна. | | |
| 4. | Арга хэмжээ 2.3: ***Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, 19.3.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоол:*** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх | Ажлын хэсгийн тушаал, удирдамж (тоогоор) | | 1 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох асуудлаар шинжээчдийн баг (5 хүн)-ийг эрүүл мэндийн сайдын томилгоогоор томилж, шинжээчдийн ажлын удирдамжийг (2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр) | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагатай орчин үеийн дэвшилтэт технологийн хэрэгцээ, шаардлагын үнэлгээг хийж, тэргүүлэх чиглэлийг боловсруулж батлуулна. | | | | Эрүүл мэндийн сайдаар батлуулсан.<br>Шинжээчдийн багийг нийт 3 удаа хуралдуулсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулж, 07 дугаар сарын 09-ний өдрийн ШУТЗ-ийн 2 дугаар хурлаар хэлэлцүүлсэн.<br><br>"**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшитэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2024 он)**"-ийг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/347 дугаар тушаал (1 дүгээр хавсралт)-аар батлуулсан. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/347 дугаар тушаал (2 дугаар хавсралт)-аар батлуулсан.<br><br>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагааны 2024 оны тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төслийн саналыг ирүүлэх тухай Эрүүл мэндийн сайдын 07 дугаар сарын 24 өдрийн 1а/3027 тоот албан бичгийг яамны мэргэжлийн салбар зөвлөлүүдэд хүргүүлж, нийт 132 төслийн саналыг цуглуулсан.<br><br>Эрүүл мэндийн сайдын А/347 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгээс сонгон шалгаруулсан дэвшилтэт технологийн төслүүдийг ШУТЗ-ийн 09 дүгээр сарын 19-ний өдрийн 3 дугаар хурлаар хэлэлцүүлж, эдгээрээс 15 төсөл, арга хэмжээг дэмжсэн шийдвэр гаргасан. ЭМХТ-д эдгээр төслийн хэрэгжүүлэгч баг, байгууллагатай гэрээ хийх үүргийг олгосны дагуу төслийн багууд гэрээгэ байгуулж, гадаад, дотоод сургалтад хамрагдах, тоног төхөөрөмж захиалах зэргээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн болно.<br>ЭМЯ-ны ШУТЗ-ийн шийдвэр 24/006-020<br><br>Түүнчлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны 2025 оны тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулах зорилгоор яамны мэргэжлийн салбар зөвлөлүүд, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга, удирдлагуудад Эрүүл мэндийн сайдын 10 дугаар сарын 28-ны өдрийн 1а/4367-4369 болон 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1а/4943-4945 тоот албан бичгүүд (санал ирүүлэх тухай)-ийг хүргүүлж, хариуг авсан болно.<br><br>Яамны цахим хуудасны Эрүүл мэндийг дэмжих сан гэсэн цэсэнд Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ын холбоосыг байршуулсан. Түүнчлэн ЭМДС-ийн санхүүжилтээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт, түүний явцтай холбоотой мэдээллийг тухай | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрт нь нээлттэйгээр байршуулж байна.<br><br>“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох журам”-ын төслийг боловсруулж, “Журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг яамны газар, хэлтсийн дарга нараар хянуулж байна. | | |
| 5. | Арга хэмжээ 2.4: ***Эрүүл мэндийн тухай хууль 37 дугаар зүйл 37.1 дэх хэсэг:*** Анагаах ухааны салбарт оношлогоо, эмчилгээний шинэ арга турших, нэвтрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх журмыг боловсруулж батлуулна. | Ажлын хэсгийн тушаал, удирдамж (тоогоор) | | 1 | Анагаах ухааны салбарт оношилгоо, эмчилгээний шинэ арга танилцуулагдсанаас эхлэн хэрэглээнд нэвтрэх хүртэлх бүх процессийн зураглалыг гаргаж, журмын төслийн хувилбарыг боловсруулсан.<br><br>Анагаах ухааны салбарт оношилгоо, эмчилгээний шинэ арга турших, нэвтрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх журмын төслийг боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, зөвлөгөө өгөх шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг батлах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг яамны | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 50 |



55

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газар, хэлтсийн дарга нараар хянуулж байна. | | |
| 6. | Арга хэмжээ 2.5: ***Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 ба 26.2 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:*** ЭМЯ-ны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо болон Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган ажиллуулна. | Хуралдааны тоо<br><br>Батлагдсан тогтоол, тушаал (тоогоор)<br><br>Сургалтын тоо/Сургалтад хамрагдсан хүний тоо | | 5-аас багагүй | Энэ онд ЭМЯ-ны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороог 10 удаа хуралдуулж, нийт 92 эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийг хэлэлцүүлснээс, шинээр судалгаа эхлүүлэх зөвшөөрлийг 51 төсөлд, судалгааг хаах дүгнэлтийг 26 төсөлд, лабораторид сорьц илгээх зөвшөөрлийг 9 төсөлд, судалгааны үргэлжлэх хугацаа сунгаж, арга аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөлийг 6 төсөлд тус тус олгосон.<br><br>ЭМЯ-ны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийг 4 удаа хуралдуулж, 25 тогтоолыг батлуулсан байна.<br><br>2024 оноос эрүүл мэндийн салбарт хэрэгжих улсын захиалгат болон цөм технологийн төслийн 77 саналаас нийт 16 захиалгын саналыг сонгон шалгаруулж, ШУТС-д хүргүүлснээс улсын захиалгат 2 төсөл (нийт өртөг нь 485 сая төгрөг), цөм технологийн 1 төсөл (нийт | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өртөг нь 520 сая төгрөг) шалгарч дэмжигдсэн.<br><br>Малайз, Сан Марино хот улс, Филиппин Улсад зохион байгуулагдсан Эмнэлзүйн туршилт судалгаа, хүний геномик, анагаахын ёс зүйн чиглэлийн хурал уулзалтуудад АУЁЗХХ-ны гишүүдээс оролцуулсан. Төрийн ордонд зохион байгуулсан Шинжлэх ухааны ажилтны II их хурал болон Үндэсний судалгааны нэгдсэн платформын санг баяжуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр зохион байгуулсан уулзалтад харьяа байгууллагын Эрдмийн зөвлөлийн төлөөллийг оролцуулсан. | | |
| 7. | **Арга хэмжээ 2.6: *Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6 дахь хэсэг:*** Эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны мэдээлэл, өгөгдлийн цахим сангийн тогтолцоог бүрдүүлэх | Шаардлагатай төсвийг бүрдүүлж чадсан эсэх (Тийм: 1 / Үгүй: 2) | | 1 | Эрүүл мэндийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, тайланг Үндэсний судалгааны нэгдсэн платформын сан (www.sudalgaa.gov.mn)-д байршуулах ажил эрчимтэй үргэлжилж байна. ЭМЯ болон түүний харьяа 16 байгууллагын судалгаа хариуцсан нэгж энэ платформд мэдээлэл оруулах | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрхийг авч, сургалтад хамрагдсанаар судалгааны санг баяжуулах үйл ажиллагаа тогтмолжсон. Одоо нийт 362 судалгааны тайланг уг санд байршуулсан байна.<br><br>Эрүүл мэндийн яамны цахим хуудасны ИЛ ТОД цэсэнд “Эрүүл мэндийн чиглэлийн судалгаа, тайлан” гэсэн дэд цэсийг үүсгэж, үүнд Үндэсний судалгааны нэгдсэн платформ https://sudalgaa.gov.mn/ -ийн Анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлийн судалгааны тайлангууд байршсан холбоосыг холбосон.<br><br>Судалгааны санг баяжуулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр сүүлийн 10 жилд хийж гүйцэтгэсэн судалгааны тайлангуудыг “Үндэсний судалгааны нэгдсэн платформ”-д байршуулах даалгаврыг яамны харьяа 16 байгууллагад Эрүүл мэндийн сайдын албан бичгээр хүргүүлсэн (2024.05.31-4/2347). | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Арга хэмжээ 2.7: ***Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт ("Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа): Зорилт 2.2.Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ. 2.2.38.Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээг хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлж аливаа өвчин эмгэгийг эрт илрүүлж, эмчлэх боломжийг бүрдүүлнэ. ЭМЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 106 дахь заалт:*** Эрүүл | Ажлын хэсгийн тушаал, удирдамж (тоогоор) | | 1 | • Хиймэл оюун ухааныг эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах туршилт судалгааны 2 төсөл (ЭХЭМҮТ-д "Умайн хүзүүний хорт хавдар, хавдрын урьдал эмгэгийн эрт илрүүлэгт хиймэл оюун ухаан ашиглах нь" олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, УАУТХ-нд "Уламжлалт анагаах ухааны оношилгооны аргуудад хиймэл оюун ухааны технологийг ашиглах нь" ШУТС-ийн санхүүжилттэй, БШУЯ-ны захиалгат төсөл)-д судалгаа эхлүүлэх зөвшөөрөл олгосон.<br>• Үндэсний түвшинд хэрэгжиж байгаа эрт илрүүлэг арга хэмжээний их өгөгдлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх судалгааны багийн ажлын хүрээнд цээжний рентген зургийн болон зүрхний цахилгаан бичлэгийн мэдээллийг хиймэл оюун ухааны програмчлалд холбох | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн салбарт хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоонд ашиглах журам батлуулах | | | | судалгааг УГТЭ-ийг түшиглэн эхлүүлж эхний үр дүнг хүлээн авсан.<br>• "Эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоонд ашиглах журам"-ын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж, яамны газар хэлтсийн дарга нараар хянуулж байна. | | |
| ГУРАВ: 2.7.4.Монгол хүний удмын сан, хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчинг бий болгоно. | | | | | | | |
| 9. | Арга хэмжээ 3.1: ***УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын 153, 2022 оны 01 дүгээр тогтоолын 1.3:*** Хүний генетикийн тухай хуулийн төслийг боловсруулна. | Тайлан (тоогоор) | | 1 | Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу<br>• Хүний генетикийн тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг дуусгасан.<br>• Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулсан.<br>• Санхүү эдийн засгийн тооцоо судалгааны | 2024 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урьдчилсан тооцоог хийсэн.<br><br>Филиппин Улсад 04 дүгээр сард зохион байгуулагдсан “Нийгмийн эрүүл мэндийг сайжруулахад хүний геномикийн ололтыг нэвтрүүлэх шинжээчдийн зөвлөлдөх уулзалт”-д оролцож, бүс нутгийн улс орнуудын Хүний генетикийн эрх зүйн зохицуулалтуудтай танилцсан.<br><br>Хөрш улсууд болон Номхон далайн баруун эргийн бүс нутгийн бусад улсуудад мөрдөгдөж байгаа Хүний генетикийн чиглэлийн хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, ололт, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг цуглуулсан. | | |

**Нэг. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээний)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 10. | ***Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл:*** Эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний сан болон мэдээлэл солилцох системийн талаар эрүүл мэндийн байгууллагад сургалт зохион байгуулах, иргэдэд зориулсан нөлөөллийн аян өрнүүлэх арга хэмжээ авах | Сургалтын тоо, сургалтад хамрагдсан хүний тоо | | Эрүүл мэндийн салбарын нийт ажилтнуудын 30-50 хувийг сургалтад хамруулах | Энэ ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын "Сургалт зохион байгуулах тухай" 2024 оны А/177 дугаар тушаалыг боловсруулж батлуулсан. Дээрх тушаалаар байгуулсан ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, 05 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаанд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" сургалтыг зохион байгуулж, нийт (24800) орчим эмч, эрүүл мэндийн ажилтныг сургалтад хамруулсан. | 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 06 /25-ны өдөр хүртэл | 100 |
| 11. | Өвчний олон улсын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | Батлагдсан тушаал<br><br>Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | Өвчний олон улсын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаж, 2024 онд төлөвлөсөн | Өвчний олон улсын 11 дүгээр ангиллын шинэ хувилбарт шилжих арга хэмжээ, үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө, 2024-2025 он"-г эцэслэн боловсруулж, Эрүүл мэндийн дэд сайдаар батлуулсан (04 дүгээр сард). Төлөвлөгөөнд тусгасны дагуу ЭМЯ-ны Мэргэжлийн салбар зөвлөлийн Ерөнхий мэргэжилтэн, гишүүдийг оролцуулсан багууд Өвчний | 2024 оны 04 дүгээр сараас 06 дугаар сар хүртэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | арга хэмжээ хэрэгжсэн байна. | олон улсын 11 дүгээр ангиллаас мэргэжлийн чиглэлд хамаарах өвчний бүлгүүдийг Монгол хэл рүү хөрвүүлэх үйл ажиллагаа хийгдэж байна.<br><br>Нэвтрүүлэх үйл ажиллагаатай холбоотой цахим уулзалт, сургалтыг нийт 3 удаа зохион байгуулав.<br><br>Мөн ДЭМБ-ын НДББ-ийн зөвлөхтэй хамтарсан цахим хурал зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөөг авсан. | | |
| 12. | ***Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг:*** Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болгоно. | Батлагдсан тушаал<br><br>Шинээр үүссэн мэдээллийн сан | Салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулсан.<br><br>Журмын төслийн эхний хувилбарыг боловсруулсан. | Амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх маягтыг батлуулж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт (2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр) оруулж магадалгааг цахим хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд бичгээр гарган магадалгааны нэгдсэн санд бүртгэдэг байх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн *(38.2.Энэ хуулийн 38.1-д заасан магадалгааг цахим хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд бичгээр гаргах бөгөөд магадалгааны нэгдсэн санд бүртгэнэ.).*<br><br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратеги судалгааны хүрээлэнгээс 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан "Амиа хорлох үзэгдлийн тархалт, шалтгаан нөхцөл" | | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлэгт "Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам"-ын төслийг хэлэлцүүлж, саналыг тусган "Амиа хорлох оролдлогыг бүртгэх маягт"-ыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 611 дүгээр тушаалын шинэчилсэн төсөлд бүрэн тусгалаа.<br><br>"Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх" сэдэвт судалгааны төслийн үр дүн, тайланг АУЁЗХХ-ны хурлаар хэлэлцүүлж судалгааг хаах дүгнэлт бүхий шийдвэр (АУЁЗХХ-ны тогтоол №24/086)-ийг батлуулсан. Мөн уг судалгааны тайланг үндэсний судалгааны нэгдсэн сангийн платформ /www.sudalgaa.gov.mn/-д байршуулав. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13. | ***Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодогын баримт "Алсын хараа – 2050" 2.2.5, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.2.2, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.1.1, Эрүүл мэндий сайдын 2022 оны А/139 дугаар тушаал:***<br><br>Эрт илрүүлгийн мэдээний санг ашиглан халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн судалгааг хийнэ. | Судалгааны ажлын явц, хувиар | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/498 дугаар тушаалаар судалгааны багийг байгуулсан, судалгааны арга аргачлал Эрдмийн зөвлөл, АУЁЗХХ-оор хэлэлцэгдэж, судалгаа эхлүүлэх зөвшөөрлийг авсан. | | Ажлын хэсгийн "их өгөгдөл " дээр ажиллах чадавхийг сайжруулах 2 өдрийн сургалтыг Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр ЭМХТ-тэй хамтран зохион байгуулж, нийт 20 судлаачдыг хамруулсан.<br><br>Сүүлийн 2 жилийн хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан (нийт **1,543,479** хүн) тав хүртэлх насны болон 6-17 насны нийт 578,473 хүүхдийн, 18-аас дээш насны нийт 446,410 насанд хүрэгчдийн мэдээлэл (их өгөгдөл)-д халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тооцоолол, дүн шинжилгээг хийж, судалгааны тайланг хэвлэлд шилжүүлсэн. "Эрт илрүүлэг-Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг"-ийг 12 дугаар сарын 06-ны өдөр АШУҮИС-тай хамтран зохион байгуулав. | 2024 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарыг дуустал | 100 |

**Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1: Мэргэжил эзэмших, боловсролын зэргээ ахиулах, томоохон судалгааны ажил хийх | Ном бичих, судалгааны төсөлд оролцох | 2023 онд ЭШХ-ыг зохион байгуулсан | "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн туршлага, сургамж" салбар дундын Эрдэм шинжилгээний хурлын Илтгэлийн хураангуйн эмхэтгэл номын дахин хянан тохиолдуулалтыг хариуцан хийж, 1500 ширхэгийг хэвлүүлсэн. | | 2024 оны 01 дүгээр сар | 2024 оны 11 дүгээр сар |
| | | | Эдгээр ЭЗ-ийн гишүүн | НЭМҮТ болон ХӨСҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж нийтдээ 17 удаагийн хуралд оролцсон. | | 2024 оны 01 дүгээр сар | 2024 оны 11 дүгээр сар |
| | | | Эрдмийн зэрэг цолтой хүн шинжээчээр ажилладаг | Эрдэм шинжилгээ, судалгааны 2 төсөл ("Гар утасны тусгай үйлчилгээ ашиглан чихрийн шижинтэй иргэдийн мэдлэг болон хяналтыг сайжруулах судалгаа", "Монголын хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний 6 дугаар судалгаа")-д шинжээчээр ажилласан. | | 2024 оны 04 дүгээр сар | 2024 оны 11 дүгээр сар |
| 2. | Арга хэмжээ 2: Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасны дагуу богино болон дунд хугацааны сургалт /төрийн албаны сургалтын байгууллагын/-ад хамрагдах | Сургалтад хамрагдаж багц цагийг биелүүлэх эсхүл шалгалт өгч гэрчилгээ авах | Энэ сургалтад 2023 оны 11 дүгээр сарын 25-наас эхлэн хамрагдсан буюу сургалт он дамнасан | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан "Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт"-ад хамрагдаж №А4447 дугаартай сертификатыг авсан. | | 2023 оны 11 дүгээр сарын 25 | 2024 оны 01 дүгээр сарын 10 |
| | | | | | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан "Үр дүнд суурилсан төлөвлөлт, | 2024 оны 09 дүгээр сарын 25 | 2024 оны 09 дүгээр сарын 26 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гүйцэтгэл" сэдэвт сургалтад хамрагдаж, 24/1255 дугаартай үнэмлэх авсан. | | |
| 3. | Арга хэмжээ 3: Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмших | Сургалтад хамрагдаж багц цагийг биелүүлэх эсхүл шалгалт өгч гэрчилгээ авах | | (JET SCHOOL OF ENGLISH) англи хэлний сургалтын төвд хэлний түвшин ахиулах курсийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. | | 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр | 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр |
| | | | | Анагаах ухааны ёс зүй (Био-этик)-н асуудлаар Малайз Улсад зохион байгуулагдсан "Номхон далайн баруун бүсийн улсуудын Эмнэлзүйн туршилт судалгааны чадавхийг бэхжүүлэх шинжээчдийн зөвлөлдөх уулзалт"-ад оролцож, илтгэл танилцуулсан. | | 2024 оны 03 дугаар сарын 21 | 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр |
| | | | | Филиппин Улсад зохион байгуулагдсан "Нийгмийн эрүүл мэндийг сайжруулахад хүний геномикийн ололтыг нэвтрүүлэх шинжээчдийн зөвлөлдөх уулзалт"- | | 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр | 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ад оролцож, бүс нутгийн улс орнуудын Хүний генетикийн эрх зүйн зохицуулалтуудтай танилцсан. | | | |

**Тайлан гаргасан:**

Эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа төлөвлөлт хариуцсан шинжээч
*(Албан тушаал)*

Дорждагвын Ганзориг /................................/
*(Нэр, гарын үсэг)*

2024 оны 12 дугаар сарын ...04...-ны өдөр
*(Огноо)*